



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 03 САР | ДУГААР 64

ГАРЧИГ



2–3	Бодлогын нийтлэл
4–7	Зохицуулалтын мэдээ
8–10	Байр суурь
11–12	Тайлбар ба зөвлөмж
13–14	Тогтвортой санхүүжилт
15–16	Компанийн засаглал, комплайнс
17–18	Финтек ба регтек
19–27	Судлаачийн индэр
28–29	Урт хугацааны даатгал гэж юу вэ?
30–31	Олон улсын зах зээлийн мэдээ
31	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ЯАГААД НОГООН САНХҮҮЖИЛТ ХЭРЭГТЭЙ ВЭ?



ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс

Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) нь ядуурлыг устгах, эх дэлхийг хамгаалах, хамтын энх тайван, аюулгүй байдлыг бий болгох улс орнуудын хамтын зорилт юм. ТХЗ-ууд нь 2030 он гэхэд тогтвортой хөгжилд хүрэх гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2015 онд НҮБ-ын гишүүн орнуудын санаачилгаар анх бий болсон. ТХЗ-ууд нь 2030 он гэхэд тогтвортой хөгжлийг цогцлоох 17 зорилго, зорилго тус бүрийг дагалдсан зорилт, индикаторуудаас бүрдэнэ. 2000–2015 оны хооронд олон улсын хөгжлийн зорилтыг биелүүлэхээр НҮБ-ын гишүүн орнуудын мөрдөж байсан 7 бүрэлдэхүүн хэсэг бүхний Мянганы хөгжлийн зорилтууд нь өдгөө ТХЗ болсон гэж ойлгож болно.

Тогтвортой хөгжлийн зорилтуудын биелэлтэд хүрэхэд дэлхий даяар бүхий л салбаруудыг хамруулан жилд 5–7 их наяд ам.долларын хөрөнгө оруулалтын хэрэгцээ байгаа хэмээн тооцоолсон байдаг. Гэвч өнөөгийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээнээс маш бага буюу их хэмжээний дутагдалтай байна. Өнөөгийн боломжит олон улсын хөрөнгө оруулалтын хэмжээ нь 200 их наяд ам.доллар хүрсэн гэж үзэж байгаа хэдий ч харамсалтай нь уг хөрөнгийн дийлэнх нь Парисын хэлэлцээрийн хүрээнд тодорхойлсон уур амьсгалын болон тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэгдэхгүй байгаа юм. Тогтвортой хөгжлийн зорилтуудаас гадна улс орнууд 2030 он гэхэд хүрэх уур амьсгалын зорилтыг тодорхойлж, үүрэг амлалт хүлээсэн. НҮБУАӨСК-ын Талуудын ХҮИ дугаар бага хурлын шийдвэрт “Хөгжиж буй орнууд нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, хэрэгжилтийн ил тод байдлыг хангуулах хүрээнд хөгжиж буй орнуудад тэдний хөгжлийн хэрэгцээг шийдвэрлэх 100 тэрбум ам.долларыг 2020 он хүртэл жил бүр зарцуулна” хэмээн тусгасан байдаг. Энэхүү үүрэг амлалт нь 2009 оноос хойших уур амьсгалын хэлцэлд томоохон үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд хөгжиж буй орнууд үүнийг тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх, ахиц дэвшил гаргах чухал баримт бичиг хэмээн хүлээн зөвшөөрч ирсэн. 100 тэрбум ам.долларын үүрэг амлалт бол олон улсын уур амьсгалын санхүүжилтийн гол суурь, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын хэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх үндсэн зарчим юм. Олон улсын уур амьсгалын санхүүжилт нь карбон бага, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй өсөлт рүү шилжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Үргэлжлэлийг 13-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Тухайн бодлогын асуудлаар судалгаа шинжилгээ хийж, бодлого боловсруулагчдад бодлогын төрөл бүрийн хувилбар, хандлагын давуу болон сул талуудын талаар тусгай мэдээлэл гаргаж өгөх үйл явц юм. Гэхдээ бодлогын шинжилгээг: бодлогыг шинжлэх – тухайн бодлого, түүнийг боловсруулсан явцыг тайлбарлах буюу шинжилгээний болон тодорхойлсон шинжтэй; бодлогод зориулсан шинжилгээ – бодлого, саналыг боловсруулахад (жишээ нь нийгмийн халамжийг сайжруулах) жор тогтоох гэсэн хоёр үндсэн салбарт хувааж үздэг.



POLICY ANALYSIS

Process of researching or analyzing public problems to provide policy makers with specific information about the range of available policy options and advantages and disadvantages of different approaches. However, policy analysis can be divided into two major fields. Analysis of policy is analytical and descriptive – i.e., it attempts to explain policies and their development. Analysis for policy is prescriptive – i.e., it is involved with formulating policies and proposals (e.g., to improve social welfare).

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН НОГДОЛ АШГИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

Сүүлийн 2–3 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээл хамгийн өндөр өсөлтийг үзүүлж, зах зээлийн үнэлгээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 11.7 их наяд төгрөг буюу түүхэн дээд хэмжээнд хүрсэн. Энэ нь зах зээлийн хөгжлийн суурь үзүүлэлтүүд өсөж, иргэд, дотоодын аж ахуйн нэгжүүдийн зах зээлд итгэх итгэл, оролцоо нэмэгдэж буйг илэрхийлж байна. Үүнийг дагаад дотоодын аж ахуйн нэгжүүдийн зүгээс хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах, нөгөө талаас үнэт цаасанд хөрөнгө оруулах иргэд, олон нийтийн сонирхол ихээхэн нэмэгдэж, тэдгээрийн эрх, ашгийг хамгаалах зохицуулалтыг нарийвчлах шаардлага үүсэж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос анх 2020 онд хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагааг тогтоолоор нарийвчлан тогтоож байсан бөгөөд энэхүү тогтоол батлагдахаас өмнөх хугацаанд ногдол ашгийг зарим хувьцаат компаниуд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулахгүйгээр компани дээрээ тараах асуудлууд их байсан нь компаниас ногдол ашиг тараах бүрд хувьцаа эзэмшигч тухайн компани дээрээс очиж ногдол ашгаа авах, зарим тохиолдолд мэдээлэл аваагүйгээс ногдол ашгаа огт аваагүй зэрэг хүндрэл, бэрхшээл гардаг байсан.

Уг асуудлыг нэг тийш нь шийдвэрлэхээр Санхүүгийн зохицуулах хорооноос 2020

онд хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох асуудлыг хэлэлцэж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хувьцаат компаниудын ногдол ашгийг зөвхөн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан тарааж байхаар тогтоосон.

Тухайлбал, 2015–2019 онуудад давхардсан тоогоор 123 компани ногдол ашиг тараах шийдвэрийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д мэдэгдсэнээс Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан 77 компани ногдол ашгаа тараалгасан байдаг. Харин Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоол батлагдсанаас хойш буюу 2020–2023 онуудад давхардсан тоогоор 150 компани ногдол ашиг тараах шийдвэрийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д мэдэгдсэнээс “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан 128 компани ногдол ашгаа тараалгасан байна. Үүнээс үзэхэд тогтоол батлагдсанаас хойших хугацаанд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан ногдол ашгаа тараалгасан компаниудын тоо 1.6 дахин өссөн байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн тухай хуулиар компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн

дотор ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 4 сарын дотор хуралдуулах зохицуулалттай. Гэтэл зарим хувьцаат компаниудын хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэрээ гаргасан хэдий ч тараах хугацаагаа хувьцаа эзэмшигчдэд тодорхой зарлаагүй, ногдол ашгаа тараахгүй удааж байгаа эсхүл хүссэн хугацаандаа ногдол ашгаа тарааж байгаа нь хувьцаа эзэмшигчдэд тодорхойгүй байдлыг бий болгохын зэрэгцээ зах зээлд итгэх итгэл болон идэвхийг бууруулах эрсдэлтэй байсан тул уг асуудлыг шийдвэрлэх практик шаардлага үүссэн.


Иймээс Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, компаниудын ногдол ашиг тараах хугацааг нарийвчлан тогтоосон. Тодруулбал, ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компаниуд санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу 04 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө ногдол ашгаа хуваарилж дуусган, тухайн ногдол ашиг хуваарилалтын тайлангаа 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байх үүргийг нийт хувьцаат компаниуд хүлээж буй юм. Ингэснээр хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан хугацаанд нь түргэн шуурхай авахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдын

зах зээлд итгэх итгэл, идэвхийг нэмэгдүүлж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой болж байна.

2024 оны хувьд хамгийн сүүлийн байдлаар нийт 45 хувьцаат компани нийт 799.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилах болсон шийдвэрээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, олон нийтэд мэдээлээд байгаа бөгөөд 2024 онд хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээг 2019 онтой харьцуулахад 8.4 дахин өссөн байна. Түүнчлэн, сүүлийн 3 жилийн байдлаар олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон 13 компаниас 10 компани нь энэ онд нийт 457.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн байна.

Үүнээс гадна Санхүүгийн зохицуулах хорооноос “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай гэрээ байгуулахгүйгээр өөрийн компанийн байранд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг бэлнээр тараахаар шийдвэр гаргасан нэр бүхий хувьцаат компаниудад үүрэг даалгавар хүргүүлж, тогтоолын хэрэгжилтийг хангуулж, зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

Зураг. 2015–2022 онд ногдол ашиг тараасан компаниуд



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГИШҮҮН ОРНУУДАД “СААРАЛ ЖАГСААЛТ”-ААС ГАРСАН ТУРШЛАГААСАА ХУВААЛЦЛАА



Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН) нь олон улсын хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр харилцан туршлага хуваалцаж, бодлого зохицуулалтын орчныг сайжруулах зорилготой ажилладаг нийгэмлэг юм. Нийгэмлэгт 84 орны 89 санхүүгийн зохицуулагч байгууллага гишүүнчлэлтэй ажилладаг. Санхүүгийн зохицуулах хороо 2010 онд гишүүнээр элссэн бөгөөд улмаар нийгэмлэгийн захирлуудын зөвлөлд 2 удаа, Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилгын даргаар 2021–2023 онд ажилласан. Ажиллах хугацаанд зах зээлийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан бүс нутгийн онцлог тохирсон бодлого зохицуулалтын шинэ санал, санаачилга дэвшүүлэн ажилласан юм. Мөн нийгэмлэгийн 7 ажлын хэсэгт идэвхтэй ажиллаж, өнгөрсөн оны есдүгээр сард Цахим санхүүгийн үйлчилгээ (DFS)–ний ажлын хэсгийн дэд ахлагчаар СЗХ–ны төлөөлөл сонгогдсон юм. Тус нийгэмлэгийн гишүүн болох 12 орон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсон бөгөөд Монгол Улсаас ФАТФ–ын “саарал жагсаалт”–аас хэрхэн гарсан туршлагаасаа хуваалцах хүсэлтийг тавьсан юм. Үүнтэй холбоотойгоор СХН–ээс цахим уулзалт зохион байгуулж, СЗХ–ны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албанаас “саарал жагсаалт”–аас гарахтай холбоотой хорооноос хэрэгжүүлсэн арга хэмжээ, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог ФАТФ–ын стандартад нийцүүлж, хамтын ажиллагааг идэвхжүүлсэн

талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар өгч, туршлагаасаа хуваалцсан юм. Түүнчлэн уг цахим уулзалтаар Ла Троб их сургуулийн профессор Лиүс дэ Кокер ФАТФ–ын “саарал жагсаалт”–ын эдийн засагт үзүүлэх хор нөлөөг тайлбарлаж, Базелийн засаглалын хороо, Зимбабве Улсын Сангийн яам мөн өөрсдийн туршлага, үнэлгээний талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүлэв.

“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯАЛТИ ТЗК” ХХК–ИЙН НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ЦАНГ ЦОХИЛОО



“Бичил Эй Би Эс лояалти ТЗК” ХХК–ийн нийтэд санал болгон гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол өнөөдөр боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Т.Итгэлсүрэн, “Монголын хөрөнгийн бирж” ХК–ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр, “Өлзий энд КО капитал ҮЦК” ХХК–ийн гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр, “Бичил глобус финанс ББСБ” ХХК–ийн гүйцэтгэх захирал С.Отгонбат болон холбогдох бусад хүмүүс оролцлоо.

Анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслолыг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал “Аж ахуйн нэгж байгууллагуудын зүгээс хөрөнгийн зах зээлийн уламжлалт бүтээгдэхүүнүүдээс гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргах замаар олон нийтээс санхүүжилт татах ажиллагаа идэвхжиж байна.

ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИЙГ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ



Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх эдийн засагт гүйцэтгэх үр нөлөө, санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/-тай хамтран “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг өнгөрсөн онд баталсан. Энэ дагуу буюу дээрх аж ахуйн нэгжүүдэд хөрөнгийн зах зээлд хувьцаа, компанийн бонд гаргахад тавих шаардлага, хугацаа, өртгийг бууруулж, хялбаршуулах зохицуулалтуудыг бүрдүүлэх, холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг хамтран боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийн анхдугаар хуралдаан боллоо.

Хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулсан юм. Тодруулбал, компаниудыг нийтэд санал болгон хувьцаа гаргахад хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, нээлттэй болон хаалттай хүрээнд тодорхой дүнгээр жилээс бага хугацаатай бонд гаргахад аливаа барьцаа, батлан даалт шаардахгүй мөн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгүүлэх тухай хүсэлтийг хялбаршуулсан горимоор хянаж, бүртгэх шийдвэрийг ажлын 10 хоногийн дотор гаргах, нээлттэй болон хаалттай хүрээнд бонд гаргахад андеррайтертай гэрээ байгуулахыг шаардахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгахаар ажиллаж буй талаар танилцуулсан юм.

Мөн хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн Солонгос, Сингапур, Австрали зэрэг орны зах зээлээ хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээ, тэдгээрийг өөрийн зах зээлд хэрхэн нутагшуулах хүрээнд хийсэн судалгааг танилцуулав. Дээрх улс оронд ашигт ажиллагаа сайтай томоохон компаниудыг нээлттэй болгож,

IPO хийлгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хууль тогтоомж, бодлого, зохицуулалтаар тодорхой дэмжлэгийг үзүүлдэг аж. Тухайлбал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, нээлттэй компани болохын давуу тал, IPO хийх үйл явц, тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх зэрэг арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг байна.


БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН БОНЗ-ЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хороо, Олон улсын санхүүгийн корпораци, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо хамтран “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан БОНЗ-ын эрсдэлийн удирдлага” сургалтыг зохион байгууллаа. Энэ сарын 13-15-ны өдрүүдэд болсон энэ удаагийн сургалтад 46 банк бус санхүүгийн байгууллагын удирдлагууд болон БОНЗ хариуцсан мэргэжилтэн зэрэг нийт 100 орчим холбогдох ажилтан оролцов. Сургалтаар олон улс болон Монгол Улс дахь БОНЗ-ын чиг хандлага, тулгамдаж буй асуудал, тогтвортой санхүүжилтийг нэвтрүүлэх хүчин зүйл, үндсэн бүрэлдэхүүн, БОНЗ-ын эрсдэлийн удирдлага, уур амьсгал, байгаль орчинтой холбоотой эрсдэлийн удирдлага, ногоон, тогтвортой санхүүжилтийн талаарх суурь ойлголтын талаар мэдээлэл, мэдлэг олголоо. Мөн Монгол Улсын байгаль орчин, хууль эрх зүйн орчны талаар болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хэрхэн хийх, үнэлгээний тайланг хянах, уур амьсгалын эрсдэлийн чиг хандлага, уул уурхай, барилга, хөдөө аж ахуйн салбарын БОНЗ-ын гол эрсдэлүүд түүнийг бууруулах арга хэмжээний талаар танилцаж, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн анхан шатны үнэлгээ хийх дадлага хийлээ.

Банк бус санхүүгийн байгууллагуудын холбогдох ажилтнууд сургалтад хамрагдсанаар БОНЗ–ын талаар суурь мэдлэгтэй болж улмаар тогтвортой санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийг олгохдоо эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах аргачлалаас суралцсан юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО УНГАРЫН ТӨВ БАНКТАЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хороо Унгар Улсын Төв банк (Magyar Nemzeti Bank)–тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан тус улсын Төв банкны дэд ерөнхийлөгч ноён Ч. Кандрач (Csaba Kandracs) нар үзэглэлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэхүү арга хэмжээний үеэр “Монгол Улсын хөрөнгийн зах зээл сүүлийн гурван жилийн хугацаанд идэвхжил өндөртэй байлаа. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3 их наяд төгрөгөөс 11 их наяд төгрөг болж гурав дахин өссөн. Мөн өнгөрсөн онд манай хөрөнгийн зах зээл олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell–ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн ангилалд орсон зэрэг хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц нэлээдгүй өөрчлөлт гарсан. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас ч Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг цаашид тогтвортой үргэлжилнэ гэсэн төсөөллийг гаргасан. Тухайлбал, Азийн хөгжлийн банк эдийн засгийн өсөлтийг энэ онд 6.4 хувь байна гэсэн бол Дэлхийн банкнаас 2024–2025 онд 6.3–6.8 хувиар өснө гэсэн урьдчилсан төсөөллийг хийсэн. Ийм учраас манай

байгууллага хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчид, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байгаа бөгөөд энэ үед хоёр байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр орны хөрөнгө оруулагчдыг идэвхжүүлэхэд бидний хамтын ажиллагаа чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна” гэдгийг онцоллоо.

Хамтын ажиллагааны хүрээнд хоёр улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг бодлогоор дэмжихийн зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд харилцан туслалцах, хил дамнансан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх хяналт, шалгалт хийхэд харилцан туслалцах мөн хүний нөөц, байгууллагыг чадавхжуулах чиглэлд хамтарч ажиллах юм.

ФИНТЕКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД УРИАЛГА ГАРГАЛАА




Санхүүгийн зохицуулах хороо, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв болон Финтекийн холбоо хамтран “FIN–SEC” форумыг зохион байгууллаа. Финтекийн экосистемд тулгарч буй кибер аюулгүй байдлын тулгамдсан сорилтуудыг төр, иргэн, хуулийн этгээд, иргэний нийгмийн байгууллагууд хамтдаа шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх зорилгоор зохион байгуулж буй энэхүү форумд финтекийн үйлчилгээ үзүүлэгч 50 гаруй байгууллагын удирдлага, мэдээллийн аюулгүй байдал, хариуцсан ажилтнууд оролцсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал форумыг нээж хэлсэн үгэндээ “Сүүлийн жилүүдэд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ хурдацтай хөгжиж байна. Финтекийн энэхүү хөгжил Монгол Улсын санхүүгийн зах зээлд ч мөн эрчимтэй нэвтэрч буй тул төрийн бодлого гаргагчид болон зохицуулагч байгууллагууд

технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, тогтвортой хөгжилд хүрэх боломжийг эрэлхийлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллагуудаас 55 нь финтек зээлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд салбарын нийт харилцагчдын 94.1 хувьд энэ үйлчилгээг үзүүлсэн байна. Харин даатгалын салбарт урт хугацааны даатгалын нэг, ердийн даатгалын 15 компани цахим технологи ашиглан нийт 72 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг, сэндроксын орчинд долоон бүтээгдэхүүнийг өдгөө ашиглаж байна. Цаашид ч бид санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд технологид суурилсан санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр турших боломжийг бий болгох, санхүүгийн хяналт, шалгалт, зохицуулалтын үйл ажиллагаанд ректек, суптек нэвтрүүлэхээр ажиллаж байна. Гэхдээ цахим технологийн хөгжил цаг хугацаа, орон зайг үл хамааран бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлдгээрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэдэг ч нөгөө талаас финтекийн систем, сүлжээн дэх эмзэг байдлыг ашиглах, кибер халдлагын бай болох эрсдэл нэмэгдэж байна. Иймд кибер аюулгүй байдлын салбарт төрийн болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг нягт уялдуулах санал санаачилгыг дэмжих, олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, зохицуулалтын стандартыг дагаж мөрдөх, олон нийтийн итгэлийг хадгалж финтекийн салбарт кибер аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах нь чухал ач холбогдолтой” гэдгийг онцолсон юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, КИРГИЗИЙН ҮНДЭСНИЙ БАНКТАЙ САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭВ

Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын ордонд болсон Санхүүгийн зохицуулах хороо Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндэсний банк (Төв Банк)-тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ёслолын арга хэмжээнд УИХ-ын дарга Г.Занданшатар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Сайд нарын танхимын дарга Акылбек Жапаров болон албаны бусад төлөөгчид оролцсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Киргизийн Үндэсний банкны дэд дарга Манас Жакыпов нар санамж бичигт гарын үсэг зурсан юм.



Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “Хил дамнасан санхүүгийн үйл ажиллагаа хурдацтай хөгжиж буй цаг үед хяналт, зохицуулалтын байгууллагуудын нягт хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд энэ үед санамж бичиг байгуулсан нь хоёр улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой, бүрэн бүтэн байдлыг хангах, салбарын оролцогч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах, бүс нутгийн санхүүгийн интеграцлалыг харилцан уялдаатай хөгжүүлэхэд өндөр ач холбогдолтой” гэдгийг онцлов. Хамтын ажиллагааны хүрээнд хоёр улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, тэр дундаа финтек компаниудыг бодлогоор дэмжих, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх санхүүгийн хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллах юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, КИРГИЗИЙН ҮНДЭСНИЙ БАНКТАЙ САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭВ

Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын ордонд болсон Санхүүгийн зохицуулах хороо Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндэсний банк (Төв Банк)-тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ёслолын арга хэмжээнд УИХ-ын дарга Г.Занданшатар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Сайд нарын танхимын дарга Акылбек Жапаров болон албаны бусад төлөөгчид оролцсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Киргизийн Үндэсний банкны дэд дарга Манас Жакыпов нар санамж бичигт гарын үсэг зурсан юм.

БАЙР СУУРЬ

ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВЬД ЦАХИМ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОНОВЧТОЙ ЗОХИЦУУЛАЛТАД АНХААРЧ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ



Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI) дэх Монгол Улсын оролцоо, нийгэмлэгийн хүрээнд олон улсын санхүүгийн системд үзүүлж буй нөлөөллийн талаар тус нийгэмлэгийн Цахим санхүүгийн үйлчилгээний ажлын хэсгийн дэд даргаар сонгогдон ажиллаж буй Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны ахлах хянан шалгагч Б.Цолмонтаятай ярилцлаа.

Сайн байна уу. Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн Цахим санхүүгийн үйлчилгээний ажлын хэсгийн дэд даргаар сонгогдсонд баяр хүргэе. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг ямар чиг үүрэгтэй байгууллага вэ?

Баярлалаа. Санхүүгийн хүртээмж гэдэг нь иргэн, хуулийн этгээд, хэн ч байсан өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээг зардал багатайгаар тогтвортой, хүртээмжтэй авах боломжтой байх ойлголт.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг нь олон улсын хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр харилцан туршлага хуваалцаж, бодлого зохицуулалтын орчныг сайжруулах зорилготой ажилладаг нийгэмлэг юм. Уг нийгэмлэгт нийтдээ 84 улс орны 89 санхүүгийн зохицуулагч байгууллагууд гишүүнчлэлтэй ажилладаг, Санхүүгийн зохицуулах хорооны хувьд 2010 онд анх гишүүнээр элсэж байсан. Өнөөгийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос энэхүү нийгэмлэгийн 7 ажлын хэсэгт идэвхтэй ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос уг ажлын хэсгүүдэд орж ажиллах нь ямар үр нөлөөтэй вэ? Ялангуяа ажлын хэсгийн

дэд ахлагчаар сонгогдсоноор ямар давуу боломжууд бий болж байна вэ?

Эдгээр дэд ажлын хэсгүүд нь олон улсын хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, шинэ чиг хандлагуудыг тодорхойлох гол тулгуур болдог. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгт тухайлсан салбар, чиглэлийн бодлого боловсруулах 7 төрлийн ажлын хэсэг ажилладаг. Үүнд:

- Хэрэглэгчийн эрх ашиг, зах зээлийн ёс зүйн ажлын хэсэг (CEMCWG);
- Цахим санхүүгийн үйлчилгээний ажлын хэсэг (DFSWG);
- Санхүүгийн хүртээмжийн өгөгдлийн ажлын хэсэг (FIDWG);
- Санхүүгийн хүртээмжийн стратегийн талаар харилцан суралцах бүлэг (FISPLG);
- Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх ажлын хэсэг (GSPWG);
- Хүртээмжтэй ногоон санхүүжилтийн ажлын хэсэг (IGFWG);
- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн ажлын хэсэг (SMEFWG).

Ажлын хэсэг тус бүр өөр өөрийн гэсэн өвөрмөц зорилго, чиг үүрэгтэй. Энэ ч хүрээнд бид “Санхүүгийн хүртээмж” гэх нэрийн дор өргөн цар хүрээнд харилцан туршлага хуваалцаж, мэдээлэл солилцох боломжтой байдаг нь тус нийгэмлэгийн гишүүн байхын хамгийн том давуу тал болдог. Ингэснээр бусад орны туршлагаас суралцаж, асуудлыг илүү олон өнцгөөс харах, сургамж болон боломжит гарц, гаргалгааг олж харах боломж олгодог. Түүнчлэн, бусдаас суралцахаас гадна өөрийн улсын туршлага, ололт, амжилтын талаар бусадтай мэдээлэл хуваалцах замаар олон улсад Монгол Улсын дуу хоолойг хүргэж, нэр хүнд, байр сууриа нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Тухайлбал, Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх (GSP) ажлын хэсгийн хүрээнд энэ оны 03 дугаар сарын 22–ны өдөр Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”–аас гарахтай холбоотойгоор харилцан туршлага солилцох цахим вебинарыг зохион байгуулсан. Энэ уулзалтаар Монгол Улс саарал жагсаалтаас хэрхэн богино хугацаанд амжилттай гарсан, энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар болон ФАТФ–ын стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр амжилттай туршлагаа хуваалцсан.

Цахим санхүүгийн үйлчилгээний ажлын хэсэг одоо ямар ажилд түлхүү анхаарч байна вэ? Ойрын ирээдүйд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тайлбарлана уу.



Энэхүү ажлын хэсэг нь цахим санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих замаар хөгжиж буй орнуудад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой. Нийгмийн эмзэг бүлгийн, алслагдмал бүсэд амьдарч буй хүмүүст санхүүгийн үйлчилгээг хүргэх чухал хөшүүрэг нь дэвшилтэт технологи

гэдгийг улс орнууд тодотгож байгаа тул манай ажлын хэсгээс финтек, виртуал хөрөнгө, төв банкны дижитал валют (CBDC), цахим төлбөр тооцоо зэрэг сэдвийн хүрээнд түлхүү ажиллаж байна.

Ажлын хэсгээс өнгөрсөн оны 11 дүгээр сард гаргасан судалгааны тайлан болох “Үндэсний финтекийн стратегийг боловсруулах бодлогын баримт бичиг” нь санхүүгийн технологийг дэмжихэд улс орнуудын баримталж буй бодлого, арга хэрэгслийг тайлбарлахаас гадна үндэсний хэмжээнд финтекийг дэмжих цогц стратегитай байхын ач холбогдол бүхий баримт бичиг болсон. Одоогийн байдлаар “Виртуал хөрөнгө болон санхүүгийн хүртээмж” сэдвийн хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд виртуал хөрөнгө болон блокчэйн технологийн нөлөө, ач холбогдол мөн эрсдэлийг судалсан маш сонирхолтой тайланг боловсруулж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагаа цахим санхүүгийн үйлчилгээтэй хэрхэн холбогддог вэ?

Технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед олон улсын хэмжээнд финтек буюу технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглан, иргэдэд түргэн, шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлыг олон улсын хэмжээнд хөндөж байгаа. Цахим санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь иргэдийг дэлхийн аль ч өнцөг булангаас шаардлагатай санхүүгийн үйлчилгээг цаг алдалгүй авах боломжоор хангаж, санхүүгийн салбарын хөгжлийг дараагийн шатанд хүргэх боломжийг бий болгож буйгаараа давуу талтай боловч нөгөө талаасаа үндэстэн дамнасан гэмт этгээдүүдэд гэмт хэрэг үйлдэх, хууль бус орлогоо нуун дарагдуулах шинэ боломжуудыг мөн олгож байгаа. Тэгэхээр энэ салбарын хөгжил нь зарим эрсдэлийг дагуулж байгаа гэж ойлгож болно. Энэ ч утгаараа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартуудад цахим технологийг харгалзан үзэх болсон.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн хувьд ч мөн энэ асуудлыг хөндөж, цахим санхүүгийн үйлчилгээтэй холбоотой үүсэж буй шинэ төрлийн эрсдэлүүдийг хэрхэн бууруулах, зохистой хэмжээнд хэрхэн зохицуулах талаар идэвхтэй ажиллаж байгаа. Монгол Улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр харьцангуй

сайн туршлагатай орны хувьд нийгэмлэгийн гишүүдэд энэ чиглэлээр туршлагаа хуваалцаж, олон улсын бодлого зохицуулалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд цахим санхүүгийн залилан луйвар Монгол Улсад гэлтгүй олон улсад нэмэгдсээр байгаа нь таны бодлоор ямар шалтгаантай вэ? Улс орнууд ямар арга хэмжээ авч ажиллах ёстой вэ? Цахим санхүүгийн үйлчилгээ ажлын хэсгийн ахлагчийн хувьд таны байр суурь?

Өмнө нь дурдсанчлан цахим технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь давуу тал олгож буйтай зэрэгцэн гэмт этгээдүүдэд нэмэлт боломжуудыг бий болгож байгаа эрсдэл бодитойгоор байсаар байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд цахим гэмт хэргийн тоо дэлхий нийтээр огцом нэмэгдсэн, манай улсын хувьд санхүүгийн залилан, луйврын гэмт хэргийн тоо өмнөх жилүүдтэй харьцуулахад 80 гаруй хувиар өссөн үзүүлэлэлтэй байна. Үүнээс нийт залилан, луйврын тохиолдлын 70 орчим хувь нь цахим гэмт хэрэг гэж бүртгэгдсэн нь яах аргагүй анхаарал татаж байна.

Цахим санхүүгийн гэмт хэрэг нэмэгдэхэд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл нь иргэдийн санхүүгийн боловсрол хангалтгүй байгаатай холбоотой. Уг төрлийн гэмт хэрэг үйлдэж буй этгээд нь ихэвчлэн мэдээ, мэдээллийн дутмаг байдал, санхүүгийн болон хууль, эрх зүйн ойлголт хангалтгүй иргэд, өндөр настнууд зэрэг тодорхой секторт чиглэгдсэн байдаг нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, албан ёсны баталгаат эх сурвалж болон хуулийн хүрэн дэх үйл ажиллагаа мэтээр олон

нийтэд ухуулах замаар худал мэдээлэлд хялбар байдлаар итгэл үнэмшил төрүүлж, энэ нь цаашилбал, иргэдийг санхүү, эд хөрөнгөөр хохироох тохиолдол гарч байна. Иймд иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, аливаа мэдээ, мэдээллийг нягтлан шалгаж хэвшлийг бий болгох чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Дараагийн нөлөөлж буй нэг хүчин зүйл нь цахим технологи болоод санхүүгийн зах зээлийн хурдацтай хөгжлийн үр дүнд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ төрөлжиж, өдөр өдрөөр хүрээгээ тэлж байна. Санхүүгийн шинэ хэрэгслүүд зах зээлд олноор нэвтэрч байгааг ашиглан дижитал хөрөнгө оруулалтын шинэ боломж хайж буй иргэд цахим гэмт хэрэгт өртөх эрсдэл нэмэгдсэн. Үүнийг бид олон улс даяар виртуал хөрөнгийн зах зээлд гарсан уналт, залилангийн хэргүүдээс харлаа. Энэ төрлийн үйл ажиллагааны онцлог нь цахимаар буюу орон зай, байршил хамаарахгүйгээр хийгддэг тул хууль бус үйл ажиллагааг тухай бүр илрүүлэн, шуурхай арга хэмжээ авахад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэдэг.

Зохицуулагч байгууллагуудын хувьд цахим санхүүгийн зах зээлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангах оновчтой зохицуулалтад мөн анхаарч ажиллах шаардлагатай байна. Иймээс олон улсын холбогдох байгууллагуудаас гаргаж буй зөвлөмж, стандартуудын уялдаа холбоог хангахаас гадна санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал байна.

Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

“ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГИЙН БАГЦЫГ ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙЖ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ”-ЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 94/А/62 дугаар хамтарсан тушаалаар “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ыг баталлаа.

Тус журмаар газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалсан тухай тусгай тэмдэглэл хийж, бүртгэхтэй холбоотой шинэ зохицуулалт нэмсэн. Ингэснээр энэ төрлийн бүртгэлийг аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал гүйцэтгэх бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад зөвхөн орон сууцны барьцаа хөрөнгө бус бусад төрлийн үл хөдлөх хөрөнгө буюу газар эзэмших эрхийн гэрчилгээг мөн адил барьцаалж, бүртгүүлэх боломжтой болж байгаа юм.

Түүнчлэн Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд эрхийн улсын бүртгэлийн зарим үйлчилгээг цахимаар бүртгэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байгаатай холбогдуулан энэ төрлийн бүртгэлийн хүсэлт, материалыг цахимаар авах зохицуулалтыг тусгаж, хүсэлтийг ажлын 15 өдөрт багтаан шийдвэрлэхээр заасан.

Зохицуулах харилцаа:

Тус журмаар үл хөдлөх хөрөнгийн барьцаатай баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг үндэслэн уг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан тухай тусгай тэмдэглэл хийж, эрхийн улсын бүртгэлд бүртгэх болон газар эзэмших эрхийн гэрчилгээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцтай холбоотой тусгай тэмдэглэл хийж, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Журмын ерөнхий бүтэц:

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Тусгай тэмдэглэл хийх

Гурав. Тусгай тэмдэглэл болон эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох

Уг журмыг шинэчлэн баталснаар үл хөдлөх хөрөнгө болон газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалж баталгаат үнэт цаас гаргах үнэт цаас гаргагчийн тоо нэмэгдэх, тэдгээрийн суурь бэхжих, тусгай тэмдэглэл хийлгэж, бүртгүүлэхтэй холбоотой үүсэж буй асуудлууд шийдвэрлэгдэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, түргэн шуурхай үзүүлэх давуу талтай юм.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ыг баталсан.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан барьцаалан зээлдүүлэх журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, байнга, ашиг олох

зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнийг бүртгэж, мөнгө хүүлэх, татвараас зайлсхийх зэрэг далд эдийн засгийг ил болгох, мөнгөн зээлийн үйл ажиллагаанаас үүсэх аливаа эрсдэлийг бууруулж, улмаар зээлдэгчдийг өрийн дарамтад орохоос сэргийлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор баталсан.

Ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Уг журам нь 8 бүлэг, 31 зүйл, 30 заалттай бөгөөд дараах хэсгээс бүрдэнэ:

1. Нийтлэг үндэслэл
2. Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага
3. Өргөдөл гаргагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах
4. Хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн өөрчлөлт
5. Салбарын өөрчлөлт
6. Гүйцэтгэх удирдлага, оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт
7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаа
8. Бусад

Зарим зохицуулалтыг тайлбарлах нь:

Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5.1–д мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон бөгөөд журмын 2.1 дэх хэсгээр хуульд зааснаас гадна дараах шаардлагыг өргөдөл гаргагч хангасан байхыг журамласан. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь баримтаар тодорхойлж, нотлох боломжтой хууль ёсны орлого байх
- Цахим мэдээллийн санд мэдээлэл илгээх, хүлээн авах, дотоод бүртгэл мэдээллийг хөтлөх боломжтой компьютер, техник, тоног төхөөрөмжтэй байх
- Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан дуу–дүрсний бичлэгийн төхөөрөмжийг аюулгүй байдал хангах зорилгоор ажлын байранд байршуулсан байх.

Өргөдөл гаргагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон журмаар тогтоосон шаардлагыг хангасан өргөдөл, хүсэлтийг цахимаар хүлээн авах, хуульд заасан хугацаанд хянаж, шийдвэрлэх, бүртгэх, бүртгэхээс татгалзах, бүртгэлийн цахим санд бүртгэх үйл ажиллагааны дарааллыг журамлан зохицуулсан.

Бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлтийг бүртгэх

Журмын 4–6 дугаар бүлэгт мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, салбар, оноосон нэр өөрчлөх, гүйцэтгэх удирдлага, менежер, хаяг байршилд өөрчлөлт оруулах зэрэг бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг анх бүртгэсэн бүртгэлийн байгууллага хуульд заасан хугацаанд хянаж, бүртгэлдээ өөрчлөлт оруулахаар зохицуулсан.

Бусад

Бүртгэх байгууллагын мэдээлэл шаардах эрх, холбогдох бүртгэлийг цахим системээр дамжуулан бүртгэх харилцаанаас гадна үйл ажиллагаа нь доголдож, түдгэлзүүлсэн этгээдийн үйл ажиллагааг сэргээх, түдгэлзүүлсэн шийдвэр нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох үйл ажиллагааг хязгаарлахгүй болохыг зохицуулж өгсөн.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ЯАГААД НОГООН САНХҮҮЖИЛТ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Эхлэл 1-р нүүрт



ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс

100 тэрбум ам.долларын үүрэг амлалт нь томоохон, ашиглагдаагүй байгаа хувийн хэвшлийн санхүүжилтийг хамарсан олон төрлийн эх үүсвэрээс бүрдэж болно. Түүнчлэн энэ нь ядуу буурай болон уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий улс орнуудад өрийн дарамт, их хэмжээний өрийн үлдэгдлээс сэргийлэх ач холбогдолтой. КОВИД-19 цар тахал нь бага болон дунд орлоготой орнуудын өрийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлсэн хэдий ч тэр хэрээрээ уур амьсгалын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлага бий болгосон. Уур амьсгал руу шууд чиглэгдсэн, цогц системтэй арга барил нь уур амьсгалын болон байгаль орчны өрийн свопыг доноруудын дэмжлэгтэйгээр нэмэгдүүлэх боломжийг бий болгодог. Хувийн хэвшлийн санхүүжилт бол одоогийн байдлаар хамгийн том, хөндөгдөөгүй байгаа хөрөнгийн томоохон эх үүсвэр юм. Хэрвээ хангалттай хэмжээний олон улсын уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэрийг эдгээр хувийн хэвшлийн санхүүжилтийг гаргахад хөшүүрэг болгон ашиглавал тэрбум, их наядаар хэмжигдэж буй санхүүжилтийн хэрэгцээг хангах бүрэн боломжтой. Хэдийгээр хувийн хэвшлийн салбарт уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг дэмжих чиг хандлага бий болж байгаа хэдий ч хувийн хэвшлийн санхүүжилт нь карбон бага, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй өөрчлөлтийг санхүүжүүлэхэд хангалттай хурдан хүрч чадахгүй байгаа дээр хамгийн гол нь тэдний санхүүжүүлж буй үйл ажиллагаанууд нь дийлэнхдээ Парисын хэлэлцээртэй уялдаагүй, хөрөнгийн дийлэнх үйл ажиллагаанууд нь карбон ялгаруулалт өндөр салбарууд байх тохиолдол цөөнгүй байна. Салбарын болон газарзүйн хүрээнд хувийн хэвшлийн уур амьсгалын санхүүжилт нь өндөр анхаарлын төвд байгаа хэвээр бөгөөд одоогийн байдлаар хувийн хэвшлийн уур амьсгалын санхүүжилтийн дийлэнх нь ахисан түвшин эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудад төвлөрсөн хэвээр байна. Уур амьсгалтай уялдан бүтцийн өөрчлөлт хийх нь карбон бага, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг бий болгох, шилжилтийг хурдасгах цорын ганц арга зам юм. Энэ нь НҮБУАӨСК-ын талуудын ХҮИ бага хурлын хувийн санхүүжилтэд тусгасан тэрбум, их наяд ам.долларын зорилтыг хурдасгах, биелүүлэхийн тулд санхүүгийн системийг сууриар нь өөрчлөх, хувийн хэвшлийн уур амьсгалын санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагыг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр бий болгож байна.

МОНГОЛ УЛСЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЦЭЭ



Уур амьсгалын өөрчлөлт Монгол Улсад: Дэлхий даяарх уур амьсгалын өөрчлөлт нь Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн системд бодитой эрсдэлийг бий болгож буй. Уур амьсгалын өөрчлөлтийн асар хүчтэй нөлөө, тухайлбал өсөн нэмэгдэж буй цаг уурын ноцтой үзэгдлүүд нь актив, олон нийтэд нээлттэй арилждаг үнэт цаас, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, компаниудад биет эрсдэлийг үүсгэж байна. Түүнчлэн карбон их ялгаруулалт бүхий салбаруудаас татгалзаж буй дэлхийн чиг хандлага нь компаниуд, нийгэмлэг, ажилтнуудад шилжилтийн эрсдэл, нөгөө талаар боломжийг ч авчирч байна. Энэхүү шилжилтийг хийхэд бэрхшээлтэй байгаа нийгмийн бүлгүүдтэй тулж ажиллах нь чухал хэдий ч нөгөө талаас Монгол Улсын өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ногоон ажлын байрыг шинээр бий болгох боломжийг үүсгэж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн биет болон шилжилтийн эрсдэлийг бодитоор

хэмжиж, тайлагнахгүй байх нь монголын компаниуд, зах зээл, иргэдийн хадгаламж, дотоодын санхүүгийн байгууллагуудын харилцагчдаа үйлчлэх байдалд аюул занал учруулах эрсдэлтэй. Тиймээс Монгол Улсын Засгийн Газар, санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санхүүгийн эрсдэлийг шийдвэр гаргалтад авч үзэх, төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийг хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглүүлэх, макро зохистой байдлыг хэрэгжүүлэх замаар үлгэрлэн манлайлал үзүүлэх өндөр хэрэгцээ бий болоод байна. Уур амьсгалын өөрчлөлтийн биет эрсдэл нь дараагийн олон арван жилд улам өсөн нэмэгдэх хүлээлттэй байна.

Даатгалын компаниудын хувьд цаг уурын ноцтой үзэгдлүүдийн давтамж нэмэгдсэнээр их хэмжээний нөхөн төлбөр төлөх шаардлага үүсэж, цаашид цаг хугацаа өнгөрөхийн хирээр энэ тренд нь зарим хөрөнгийг даатгах боломжгүй байдалд аваачих ч боломжтой. Харин банкуудын хувьд зарим үл хөдлөх хөрөнгө нь уур амьсгалын эрсдэлд тэсвэртэй биш бол тэдгээрийг зээлийн барьцаанд авахад хүндрэлтэй болж, зээл олголт гаргахад хэцүү болж ирнэ. Цаашлаад барьцааны чанар муудаж, зээлдэгч өөрийн барьцаа хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлтөд алдсанаар чанаргүй зээл гаарах, ашигт ажиллагаа буурах гэх мэт асуудлууд үүснэ. Жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарын зээлдэгчдийн хувьд цаг уурын үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлтөөс хамааран ган, ургацын хэмжээ буурснаар зээлээ эргэн төлөх чадваргүй болох эрсдэлтэй болно. Энэ мэт эрсдэлүүд нь санхүүгийн байгууллагын тогтвортой, бат бөх байдалд нөлөөлж, цаашлаад санхүүгийн системийн тогтвортой байдал, макро эдийн засгийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Санхүүгийн тогтвортой байдал: Уур амьсгалын эрсдэл нь санхүүгийн эрсдэл ч мөн бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж үлдэх урьдач нөхцөл болно. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүний бодит биет эрсдэлийг бууруулахад эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай. Гэвч энэ өөрчлөлтийг хийх нь өөрөө шилжилтийн эрсдэлийг давхар үүсгэнэ. Түүнээс гадна уур амьсгалд ээлтэй нүүрстөрөгчийн тэг ялгарал бүхий эдийн засаг (нүүрстөрөгчийн татвар, хязгаар, бохирдуулагч технологиудыг хориглох г.м), түүнтэй уялдсан хурдацтай технологийн өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн байгаль орчны бодлогууд ч хэрэгтэй болно. Хэрэв эдийн засгийг ногооруулах үйл ажиллагаа хэтэрхий хожимдсон, цаг үетэйгээ нийцэхэд томоохон алхмууд хийх шаардлагатай болсон бол энэ нь эдийн засаг, санхүүгийн системд эрсдэл авчирна гэдгийг урьдаас тооцоолох нь зүйтэй. Олон улсын валютын сан (ОУВС)-гийн No.21/251 дугаартай Монгол Улсад зориулсан тайлан, түүний удирдах зөвлөлөөс гаргасан үнэлгээнд Монгол Улсыг тогтвортой, хүртээмжтэй, ногоон хөгжилд суурилсан урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай гэж үзэн эс бөгөөс тодорхой эрсдэлүүд учрах тухай зөвлөсөн байдаг. Тайлангийн эрсдэлийн үнэлгээний матрицад цаг уурын ноцтой үзэгдлүүдийг санхүүгийн системд дунд зэргийн эрсдэлтэй хэмээн авч үзсэн бөгөөд цаг уурын тодорхойгүй байдал, температурын өсөлт, цаг уурын ноцтой үзэгдэл зэрэг нь газрын доройтол бий болгож, мал аж ахуйн салбарт ноцтой

эрсдэлүүд авчирч, нийгэм эдийн засгийн өндөр зардал, удаан хөгжлийг бий болгох эрсдэлтэй тухай дурдсан байна. Тиймээс хөдөө аж ахуйн салбарыг бүтээмжтэй, уур амьсгалын шок болон өндөр температурт тэсвэртэй болгох, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах шаардлагатай.

Санхүүжилтийн хэрэгцээ: Урьдчилсан тооцоолоор Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд 2021–2030 оны хооронд 280 их наяд төгрөг, харин дараагийн 10 жилд жил бүр 28 их наяд төгрөг буюу жилийн ДНБ-ий 70 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт шаардлагатай гэжээ. Уг санхүүжилтийн хэрэгцээг хангахын тулд дотоодын нөөц хөрөнгө ялангуяа хувийн хэвшлийн санхүүжилтийг дайчлах, оффшор зах зээлээс нэмэлт санхүүжилт татах шаардлагатай байна. Монгол Улсын шинэчилсэн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтод ХХЯ бууралтын зорилтыг 22.7 хувьд нөхцөлгүйгээр хүргэх, 2010 оны суурь нөхцөлтэй харьцуулахад нийт 44.9 хувийг олон улсын туслалцаатайгаар 2030 он гэхэд бууруулах боломжтой гэсэн тооцоолол бий. Зорилтыг биелүүлэхдээ ХХЯ-ыг эрчим хүч, тээвэр, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, боловсруулах болон хог хаягдлын салбараас бууруулна. ҮХТХНЗ-д мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чанарын зорилтуудыг дараах салбарт тодорхойлсон. Үүнд: мал аж ахуй болон бэлчээр, газар тариалан, усны нөөц, ойн нөөц, биологийн олон янз байдал, байгалийн гамшиг, нийтийн эрүүл мэнд, нийгэм хамгааллын салбар багтана. Шинэчлэн тогтоосон ҮХТХНЗ-ыг биелүүлэхэд нийт 11.5 тэрбум ам.доллар, түүнээс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад 6.3 тэрбум ам.доллар, дасан зохицох үйл ажиллагаанд 5.2 тэрбум ам.долларын санхүүжилт шаардлагатай гэсэн тооцоолол бий.

Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Парисын хэлэлцээрээр хүлээсэн Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх, эрүүл, аюулгүй, хүн байгальдаа ээлтэй ирээдүйг цогцлоход төр, хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Тамгын Газар, ТоС Холбоо болон бусад хамтрагч байгууллагуудын хамтран зохион байгуулдаг ТоС Форум арга хэмжээнд Монгол Улсын бодлого тодорхойлогчид, банк, санхүүгийн салбарын зохицуулагчид болон бизнесийн байгууллагууд, мэргэжилтнүүд, иргэний нийгмийн төлөөллүүд хуран цугладаг уламжлалтай. Энэ жилийн ТоС Форум 2024 арга хэмжээний хувьд өнөөдөр нийгэмд тулгараад буй байгаль орчин, нийгмийн гол асуудлуудыг ногоон санхүүжилтийн хэрэгслээр шийдвэрлэх гарц, арга замыг тодорхойлох, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой юм.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

Үргэлжлэл...

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН 2024 ОН БОЛОН ЦААШДЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГ ХАНДЛАГА

– ДЭЛХИЙН НИЙТИЙН ЧИГ ХАНДЛАГА –

Европын холбоо (ЕХ)-ны улс орнуудад БОНЗ-ын тайлан ач холбогдлын хувьд өндөр хэвээр байна:

ЕХ-нд үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд тогтвортой байдлын тайлагналыг чухалчлан Corporate Sustainability Reporting Directive (CSRD)-ийг 2024 онд нэвтрүүлэх эхний алхмуудыг хэрэгжүүлэх бөгөөд 2026 он гэхэд бүрэн хэмжээгээр нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Компанийн ТУЗ-үүд CSRD-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тайлагналдаа анхаарал хандуулснаар тогтвортой байдлын чиглэлээр тэргүүлэгч болох боломж нээгдэж улмаар ЕХ-ны хэмжээнд нэвтрүүлэхэд идэвхтэй оролцож, хувь нэмэр оруулснаар үр дүнтэй тайлагналын орчныг бүрдүүлэх боломжтой.

Азид суурилсан үйл ажиллагааны идэвхжил өндөржиж байна:

Ази тивийн хэмжээнд хувьцаа эзэмшигчдийн идэвхжил АНУ-тай адил анхаарлын төвд байна. Энэ нь Азид төвлөрсөн компаниуд доогуур үнэлэгдсэнтэй холбоотойгоор тэдгээрийн хувьцаа эзэмшигчид компаниудад шахалт үзүүлж эхэлсэн байна.

Хувьцаа эзэмшигчид компанид оруулсан хөрөнгө оруулалтаа үнэ цэнтэй байлгахыг шаардахын зэрэгцээгээр БОНЗ-ын хүчин зүйлсүүд нь тэдний үйл ажиллагааг идэвхжүүлж, анхаарал хандуулахад хүргэж байна. Жишээлбэл, Япон улсад хувьцаа эзэмшигчид компаниудыг бэлэн мөнгөний өгөөжийг хүртээж эхлэхийг шаардаад эхэлсэн аж.

Латин Америкийн компаниуд хуулийн хийдлийг арилгах баталгааг хөрөнгө оруулагчдад өгч эхэлжээ:

Латин Америкийн зохицуулагч байгууллагуудын хөрөнгө оруулагчдыг хамгаалах эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх явц удаашралтай байгаа нь хувьцаа эзэмшигчдийн хувьд хөрөнгө оруулалт хийхэд тодорхой хэмжээний эрсдэлтэй бөгөөд эргэлзээтэй байдалд хүргэж байна.

Өнөөгийн хуулийн хийдэл нь эсрэгээрээ компаниудад боломж олгох юм. Өөрөөр хэлбэл, ТУЗ-үүд компанийн засаглалын туршлагад үндэслэн хөрөнгө оруулагчдад хүссэн баталгааг нь гаргах боломжтой. Энэ нь Латин Америк дахь компаниудын нэр хүндийг өсгөхөөс гадна олон улсын болон АНУ, ЕХ-ны улс орнуудад хэрэгждэг ил тод, нээлттэй байдлын жишиг үзүүлэлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх амлалт байж болно.

Израил-Палестины дайн компаниудын ТУЗ-д сорилт болж байна:

Израил-Палестины хямрал бүхий л талуудад ихээхэн бэрхшээл учруулж байгаа бөгөөд компаниудын ТУЗ, түүний бүрэлдэхүүн болон хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн ашиг сонирхол, үзэл суртлын хоорондох ялгавартай байдалд тохируулан ажиллаж, түүнийг зохицуулах хэцүүхэн сорилттой тулгарч болзошгүй байна. Энэхүү бэрхшээл нь ирж буй 2024 онд тулгарах хүндхэн сорилт болж магадгүй ч нөгөө талаас оролцогч талуудын үзэл бодлыг сонсож, тэдэнд харилцан уян хатан хандах боломж ТУЗ-д хадгалагдана.

Үүний зэрэгцээ дайны улмаас бүс нутгийн болон дэлхийн улс орнуудад нөлөөлж болзошгүй инфляц, газрын тосны үнийн өсөлт зэрэг нь эдийн засгийн нөхцөл байдлыг улам хурцатгаж, олон компаниуд дунд, урт хугацааны стратегидаа аажим аажмаар өөрчлөлт оруулж болзошгүй юм.

Он	Чиг хандлага		
2023	Хувьцаа эзэмшигчдийн хүсэлт сонирхолд нийцүүлэх	Хиймэл оюун ухаан (AI)-ыг бизнесийн орчинд нэвтрүүлэх	Ажлын байрны цомхотгол болон шинээр ажилтан авснаар гарч болох ур чадварын хомсдол
2022	Тогтвортой байдлын тайланг стандартжуулах	ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хүйсийн харьцаанд анхаарч, арьс өнгө, үндэстний цөөнхийн төлөөллийг нэмэгдүүлэх	ТУЗ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, чанар
2021	Байгаль орчин, нийгмийн асуудалд анхаарах	Нийгмийн хариуцлагын асуудалд анхаарч, нийгэмд нөлөөлөх ач холбогдлыг нэмэгдүүлэх	ТУЗ-өөс байгууллагын соёл, ажилтны ёс зүйн хэрэгжилтийн хяналт
2020	Зайнаас ажиллахыг дэмжих	ТУЗ-ийн бүрэлдэхүүний олон талт байдал, үйл ажиллагааны үр дүнтэй байдалд анхаарах	Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал
2019	ТУЗ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанарыг сайжруулах	Засаглалыг байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх хэрэгсэл болгох	БОНЗ-ын асуудлыг ТУЗ болон хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд хүргэх
2018	Хөрөнгө оруулагчдын хүлээлтэд анхаарах	Хөрөнгө оруулагчтай харилцах харилцааг бэхжүүлэх	ТУЗ-ийн бүрэлдэхүүний бүтэц, мэдлэг, ур чадвар
2017	Засаглалын нийтлэг туршлагыг хэрэгжүүлэх	ТУЗ үйл ажиллагааныхаа гүйцэтгэлд хариуцлага хүлээх	ТУЗ-ийн бизнесийн үйл ажиллагаанд тавих хяналт
2016	ТУЗ-ийн хараат гишүүний талаарх хувьцаа эзэмшигчдийн эргэлзээ	Ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд засаглалын зохицуулалтыг сайжруулах	БОНЗ-ын хүчин зүйлстэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн оролцоо нэмэгдэх

Компанийн засаглалын тогтолцооны таамаглал:

Компанийн засаглалын тэргүүлэх чиг хандлагыг нэн тэргүүнд хүлээн зөвшөөрч ойлгох нь ач холбогдолтой ба бизнесийн орчин хөгжихийн хэрээр хувьсан өөрчлөгдөж буй засаглалын тогтолцоог эзэнгшүүлэн нэвтрүүлж, түүнтэй хөл нийлүүлэн алхах нь мөн адил чухалд тооцогдож байна.

Компанийн засаглалын тогтолцоог төлөвшүүлснээр харилцан аюулгүй хамтын ажиллагаа, мэдээллийн тасралтгүй урсгал, БОНЗ, кибер аюулгүй байдал болон тулгарч болзошгүй бусад эрсдэлийг бодит цагийн горимоор хянаж байх боломж бий болдог.

Эх сурвалж: www.deloitte.com

ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕКИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ финтекийн кибер аюулгүй байдлын талаар болон түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Финтек нь санхүү болон технологийн хослол, тийм ч учраас санхүүгийн байгууллагууд технологи ашиглана дижитал үйл ажиллагаа эрхлэх нь кибер халдлагад өртөх эрсдэлийг үүсгэдэг.

Энгийнээр финтекийн кибер аюулгүй байдлыг тайлбарлавал: финтек компаниуд өөрсдийн дижитал систем, сүлжээ, өгөгдлийг кибер аюул заналхийллээс хамгаалахын тулд авч буй арга хэмжээг хэлнэ. Эдгээр аюул заналхийлэлд хакердах, хортой программ хангамж, фишинг, өгөгдлийн зөрчил зэрэг янз бүрийн төрлийн халдлагууд багтдаг бөгөөд энэ нь санхүүгийн эмзэг мэдээллийг алдагдуулж, финтек үйлчилгээнд саад учруулдаг.

Финтекийн компаниуд кибер аюулгүй байдлыг хангахын тулд шифрлэлт, firewall, давхар баталгаажуулалт, халдлагыг илрүүлэх систем зэрэг олон төрлийн аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тэд мөн эмзэг байдлыг илрүүлэх, хамгаалалтаа бэхжүүлэхийн тулд аюулгүй байдлын аудит, үнэлгээг тогтмол хийдэг.

Финтекийн кибер аюулгүй байдал нь хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах, салбарын итгэлцлийг хадгалах, зохицуулалтыг дагаж мөрдөх, финтек үйлчилгээний тасалдалгүй ажиллагааг хангахад чухал үүрэгтэй. Финтекийн компаниуд кибер аюулгүй байдлыг чухалчилснаар өөрсдийгөө болон үйлчлүүлэгчдээ кибер аюулаас хамгаалж, дижитал санхүүгийн экосистемд инновац, өсөлтийн найдвартай суурийг бий болгодог.

Финтекийн салбарт кибер аюулгүй байдлын ач холбогдол:

Санхүүгийн хөрөнгийг хамгаалах: Финтек компаниуд хувийн мэдээлэл, төлбөрийн мэдээлэл, гүйлгээний бүртгэл зэрэг санхүүгийн эмзэг мэдээлэлтэй харьцдаг. Энэ мэдээллийг зөвшөөрөлгүй нэвтрэх, хулгайлах, залилан мэхлэх зэргээс хамгаалахад кибер аюулгүй байдлын арга хэмжээ маш чухал юм.

Салбарын итгэл ба нэр хүнд: Финтекийн салбарт хэрэглэгчийн

итгэлийг хадгалах нь хамгийн чухал. Кибер аюулгүй байдлын зөрчил нь үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын итгэлийг алдахад хүргэдэг. Кибер аюулаас хамгаалах нь финтек компаниудын нэр хүнд, найдвартай байдлыг хадгалахад тусалдаг.

Дагаж мөрдөх шаардлага: Финтек компаниуд өгөгдөл хамгаалах хууль, салбарын тусгай зохицуулалт зэрэг зохицуулалтын хатуу стандарт, дагаж мөрдөх шаардлагуудыг дагаж мөрддөг. Эдгээр журмыг дагаж мөрдөх нь нууц мэдээллийг хамгаалах, зохицуулалтын хэрэгжилтийг хангахын тулд эдгээр арга хэмжээ авах шаардлагатай.

Санхүүгийн тогтвортой байдал: Кибер халдлага нь финтекийн бизнест ихээхэн хэмжээний санхүүгийн үр дагавартай байж болно. Хулгай, залилан гэх мэт санхүүгийн шууд алдагдлаас гадна кибер осол нь хуулийн зардал, зохицуулалтын торгууль, нэр хүндэд хохирол учруулдаг. Финтекийн компаниудын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад кибер аюулгүй байдалд хөрөнгө оруулах нь чухал юм.

Үйл ажиллагааны тасралтгүй байдал: Финтекийн үйлчилгээ нь дижитал дэд бүтэц, онлайн платформ дээр тулгуурладаг. DDoS эсвэл ransomware зэрэг кибер халдлага нь үйл ажиллагааг тасалдуулж, зогсолтыг бий болгож, санхүүгийн алдагдал, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжгүй байдалд хүргэдэг. Кибер аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх нь үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж, үйлчилгээний тасалдал үүсэх эрсдэлийг бууруулдаг.


Инновац ба өсөлт: Кибер аюулгүй байдал нь инновацыг дэмжих, финтекийн салбарт өсөлтийг бий болгоход чухал ач холбогдолтой. Компаниуд кибер аюулгүй байдлыг чухалчилснаар мэдээллийн хамгаалалтыг алдагдуулахгүйгээр аюулгүй платформ, шинэлэг шийдлүүдийг бий болгож чадна. Энэ нь финтекийн компаниудын санал болгож буй бүтээгдэхүүнээ өргөжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэх, үйлчлүүлэгчдийг өөрсдөдөө татах боломжийг олгодог.

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тойм 2024 оны хоёрдугаар сард

нийтлэгдсэн дугаарт финтек кибер аюулгүй байдлын нийт хөрөнгө оруулалт 2023 онд 1.3 тэрбум ам.долларт хүрсэн нь 2021 онд 4.4 тэрбум ам.долларын дээд амжилт тогтоож байснаас мэдэгдэхүйц буурсан үзүүлэлт юм. 2023 оны хоёрдугаар хагаст үйл ажиллагаа мэдэгдэхүйц удааширч, хамгийн том гэрээ нь АНУ-д төвтэй хиймэл оюун ухааны

аюулгүй байдлын платформ 100 сая ам.долларын хөрөнгө оруулалт босгосон явдал юм. Гэсэн хэдий ч хиймэл оюун ухаанд суурилсан аюулгүй байдлын шийдлүүдийн сонирхол нэмэгдэж байгаа нь 2024 оны эхний хагаст кибер аюулгүй байдлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй.

Зураг. Хөрөнгө оруулалтын хэмжээ



Эх сурвалж: KPMG International

Корпорациуд аюулгүй код (secure code) дээр анхаарлаа төвлөрүүлж байна: Аюулгүй кодын хөгжүүлэлт нь ялангуяа технологийн аваргууд, апп хөгжүүлэлтийн платформууд, кибер аюулгүй байдлын компаниудын дунд ихээхэн анхаарал татаж байна. Кодчлолын үйл ажиллагаа хурдацтай явагдаж, хөгжүүлэгчид AI загваруудыг ашигласнаас болж кодын аюулгүй байдлын талаар санаа зовж байсан. Аюулгүй кодыг хурдасгах, дизайныг хамгаалах бодлогыг дэмжихэд чиглэсэн шийдлүүд олны анхаарлыг татав.

Threat intelligence-д анхаарлаа хандуулж байна: Кибер аюул заналхийлэл, тэр дундаа хиймэл оюун ухаан ашигладаг аюул өсөхийн хэрээр Threat intelligence-г цуглуулах, ашиглах асуудалд анхаарал хандуулсан.

2024 оны финтекийн кибер аюулгүй байдлын анхаарах гол чиг хандлага:

- Хиймэл оюун ухааны загваруудын дотор кибер аюулгүй байдлын шийдлүүдийг сайжруулах, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор хиймэл оюун ухааны хэрэглээ нэмэгдэнэ.
- Threat intelligence платформ, автоматжуулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт нэмэгдэх болно.

2023 оны хоёрдугаар хагаст кибер аюулгүй байдлын салбарын онцлох үйл явдлуудад:

Томоохон технологийн компаниуд хиймэл оюун ухааныг хүлээн зөвшөөрч байна: Хөрөнгө оруулалт бага байсан ч хиймэл оюун ухаанд суурилсан кибер аюулгүй байдлын шийдлүүдийн сонирхол нэмэгдэж, томоохон технологийн фирмүүд эдгээр бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлсэн. Microsoft аюулгүй байдлын багуудад зориулсан хиймэл оюун ухааны дижитал туслах болох Microsoft Security Copilot-оо танилцуулсан бол Google нь Cloud Security AI Workbench-ээ гаргасан.

- Цахим аюулын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийдэг системд илүү их мөнгө зарцуулж байна. Түүнчлэн кибер аюулыг хурдан илрүүлж, хариу үйлдэл үзүүлэх боломжтой платформ, ялангуяа гуравдагч этгээдийн² удирддаг платформуудыг ашиглахад ихээхэн анхаарал хандуулж байна.
- Компаниуд Cloud дээр суурилсан онлайн таних системийг сонирхож байна.
- Томоохон технологийн компаниуд өөрсдийн платформдоо чухал шийдлүүдийг нэгтгэхийн тулд кибер аюулгүй байдлын жижиг стартапуудыг үргэлжлүүлэн худалдан авах болно.
- Threat intelligence¹ – кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн зохион байгуулж, дүн шинжилгээ хийдэг кибер халдлагын талаарх нотолгоонд суурилсан мэдээлэл.
- Гуравдагч этгээд – кибер аюулыг удирдах, хариу арга хэмжээ авахад тусгай шийдэл, тусламж санал болгодог гаднын үйлчилгээ үзүүлэгч эсвэл үйлчилгээг хэлнэ.

¹ Threat intelligence – кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн зохион байгуулж, дүн шинжилгээ хийдэг кибер халдлагын талаарх нотолгоонд суурилсан мэдээлэл.

² Гуравдагч этгээд – кибер аюулыг удирдах, хариу арга хэмжээ авахад тусгай шийдэл, тусламж санал болгодог гаднын үйлчилгээ үзүүлэгч эсвэл үйлчилгээг хэлнэ.

СУДЛААЧИЙН ИНДЭР

БИЗНЕСИЙН МӨЧЛӨГИЙН УНАЛТЫН ҮЕД ОНОВЧТОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ БҮРДҮҮЛЭХ БОЛОМЖ, АРГА ЗАМ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутан Б.Намуунаа
namuunkya@gmail.com

Удирдагч багш: СЭЗИС-ийн дэд профессор, эдийн засагч
Ж.Дэлгэрсайхан

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар бизнесийн мөчлөгийн уналтын үед Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудын хувьцаагаар оновчтой буюу өгөгдсөн өгөөжийн түвшинд эрсдэл бага байх хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэх боломж, хэрэгжүүлэх арга замыг судлав. Бизнесийн мөчлөгийг тодорхойлохдоо Монгол Улсын эдийн засгийн мөчлөгт нөлөөлөгч 5 хүчин зүйлсийг сонгож, багц бүрдүүлэхдээ Марковицын багцын онол дээр үндэслэн тодорхойлсон уналтын үеүдэд хүнсний үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, жижиглэн худалдаа, арьсан бүтээгдэхүүний салбарын хувьцаанууд сайн гүйцэтгэлтэй ажилладаг гэсэн үр дүнд хүрлээ.

УДИРТГАЛ

Хувь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын шийдвэртээ бизнесийн мөчлөгийг төдийлөн тусгаагүйгээс болж мөчлөгийн уналтын үед сэтгэлзүйн хувьд айдас түгшүүртэй мэдрэмж авч, оновчгүй шийдвэр гарган алдагдал хүлээх магадлал өндөр байна. Нөгөөтээгүүр хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгө оруулалтаасаа өгөөж хүртэхийн тулд тодорхой хэмжээний эрсдэлтэй тулгардаг бөгөөд мөчлөгийн энэ үед энгийн үеэс эрсдэл нь өндөр, өгөөж бага байх хандлагатай байдаг. Ерөнхийдөө эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлтийн жил нь уналтын жилээсээ урт байдаг гэх ерөнхий төлөв ажиглагддаг учраас хөрөнгө оруулагчид уналтын болон ёроол үед оновчтой хөрөнгө оруулалт хийвэл тэлэлтийн үед өндөр ашиг хүртэх боломжтой.

Бизнесийн мөчлөгийн уналтын үед Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үнэт цааснуудаас хөрөнгө оруулагчдад тохирсон, оновчтой хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, багц бүрдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нь судалгааны ажлын зорилго юм. Иймд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

- Бизнесийн мөчлөг болон хөрөнгө оруулалтын талаар онолын судалгаа хийж дүгнэлт өгөх;
- Монгол Улсын эдийн засаг, бизнесийн мөчлөг, хөрөнгийн зах зээлийн талаар судалгаа хийж дүгнэлт өгөх;
- Бизнесийн мөчлөгийн уналтын үед оновчтой багц бүрдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Олон улсад судлагдсан байдлын тойм

Хүснэгт. Судалгааны ажлын олон улсад судлагдсан байдал

№	Судлаачийн нэр	Судалгааны ажлын нэр	Агуулга
1	Markus Leippold, Vincent Wolff, 2022	Stock Market Liquidity, Monetary Policy and the Business Cycle	Судлаачид тус судалгаагаар хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар нь ирээдүйн эдийн засгийн үйл ажиллагааны тэргүүлэгч индикатор болдог хэмээн дүгнэжээ.
2	Roberto Gomez Cram, 2021	Late to Recessions: Stocks and the Business Cycle	Энэхүү судалгааны ажлын хүрээнд бизнесийн мөчлөгийг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан эргэлтийн цэгийг тодорхойлсон бөгөөд эдийн засгийн уналтын үед өгөөж сөрөг байдаг ба хэсэг хугацааны дараа өсдөг гэж дүгнэжээ. Мөн хөрөнгө оруулагчид хямралын үед удаан хариу үйлдэл үзүүлдэг байна. Тухайлбал, ямар нэгэн үнэт цаасны хүлээгдэж буй өгөөж сөрөг байх үед шинжээчид ирээдүйд өснө гэж таамаглан хүлээдэг аж.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дотоодод судлагдсан байдлын тойм

Хүснэгт. Судалгааны ажлын дотоодод судлагдсан байдал

№	Судлаачийн нэр	Судалгааны ажлын нэр	Судалгааны үр дүн
1	Д.Ган-Очир, Б.Цэнгүүнжав, Д.Цэнддорж, Б.Мөнхбаяр, 2017	Монгол улсын эдийн засгийн мөчлөг, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс	Манай Улсад 2000 оноос хойш нийт 2 удаагийн эдийн засгийн бүтэн мөчлөг бий болжээ. Эдийн засгийн мөчлөгийг бий болгогч үндсэн хүчин зүйлс нь дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, түүнийг дотоодын эдийн засагт дамжуулж буй мөчлөг дагасан макро эдийн засгийн бодлого, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлд гарч буй өөрчлөлт зэрэг байна.
2	С.Мягмарсүрэн, 2017	Монгол улсын санхүүгийн мөчлөгийг тодорхойлох нь	Монгол Улсын санхүүгийн мөчлөг бизнесийн мөчлөгөөс илүү давтамж багатай, далайц өндөртэй байдаг буюу санхүүгийн бүтэн мөчлөгийн хугацаа бизнесийн бүтэн мөчлөгөөс 2 дахин урт, хэлбэлзэл нь 2 дахин өндөр байдаг гэж тооцоолжээ.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Энэхүү сэдвийн гадаадад судлагдсан байдлын хувьд бизнесийн мөчлөгийг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй буюу мөчлөгийг зөв таамаглаж хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагчдад оновчтой шийдвэр гаргах боломжийг бий болгоно гэж үзжээ. Бизнесийн мөчлөг нь эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн хэлбэлзлийг харуулдаг бөгөөд хөрөнгийн гүйцэтгэлийг тодорхойлох чухал хүчин зүйл болдог бөгөөд эл гүйцэтгэл нь бизнесийн мөчлөгийн үе шат бүрд ялгаатай байдаг аж.


Дотоодод судлагдсан байдлын хувьд бизнесийн мөчлөгийг Монголбанкнаас хамгийн сүүлийн байдлаар 2017 онд тодорхойлжээ. Манай улсад бизнесийн мөчлөгийг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ашиглахтай холбоотой судалгаанууд тун ховор байна. Харин хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэхтэй холбоотой судалгааны ажлуудын хувьд хөрөнгө оруулагчийн эрсдэлд хандах хандлагад тулгуурлан хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын аргаар хувьцааны хөрөнгө оруулалтын оновчтой багцыг бүрдүүлжээ.

ОНОЛЫН ТОЙМ

Бизнесийн мөчлөг, төрлүүдийн тухай

Эдийн засаг дахь өсөлт болон уналтын хоорондох эдийн засгийн хэлбэлзлийг бизнесийн мөчлөг гэнэ. Энэхүү мөчлөгийг дотоодын нийт бүтээгдэхүүн, хүүгийн түвшин, ажил эрхлэлт, хэрэглээний зардал (consumer spending) зэргээс харгалзаж мөчлөгийн аль үе шатанд явж байгааг тодорхойлох боломжтой. Тус мөчлөг нь ерөнхийдөө давтагдах шинжтэй боловч үе үе биш буюу үргэлжлэх хугацааны хувьд нэг жилээс 10 эсвэл 12 жил хүртэл хэлбэлздэг. (CFA, 2022)

Зураг. Бизнесийн мөчлөгийн үе шатууд



Эх сурвалж: *slidemodel.com*

Бизнесийн мөчлөгийн үе шатуудыг өсөлт, оргил, уналт, ёроол үе хэмээн дөрөв ангилдаг. Үе шат бүрийн үргэлжлэх хугацаа харилцан адилгүй байж болох ба бизнесийн мөчлөгийн цаг хугацаа нь засгийн газрын бодлого, дэлхийн эдийн засгийн чиг хандлага, технологийн дэвшил зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж болно.

Бизнесийн мөчлөг оргил цэгт хүрснээр уналтын үе болж эргэлтийн цэг бий болдог учраас энэ үе шатанд эдийн засгийн үйл ажиллагаа удааширч, ажил эрхлэлт, үйлдвэрлэл, хэрэглээний зардал буурч эхэлдэг. Энэ үе шат нь ихэвчлэн эрэлтийн бууралт, эдийн засгийн уналт, байгалийн гамшиг, геополитикийн үйл явдал зэрэг гаднын нөлөөллөөс үүдэлтэй.

Бизнесийн мөчлөг болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт нь бизнесийн мөчлөгтэй нягт уялдаа холбоотой. Эдийн засгийн өсөлтийн үед бизнесүүд шинэ төслүүдэд илүү их хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх хандлагатай байдаг. Учир нь тэд эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөвт илүү итгэлтэй болж, хөрөнгө оруулалтаасаа өндөр өгөөж хүртэх сонирхолтой. Харин эсрэгээрээ эдийн засгийн уналт эсвэл хямралын үед бизнесүүд хөрөнгө оруулалтын зардлаа бууруулж, тодорхой нөхцөл байдалд шинээр хөрөнгө оруулалт хийхээс татгалздаг байна.

Мөн бизнесийн мөчлөг нь хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн бэлэн байдалд нөлөөлж болох юм. Учир нь эдийн засгийн тэлэлтийн үед зээл авах боломж илүү болж, зээлийн хүү бага байх тул бизнес эрхлэгчдэд зээл авах, хөрөнгө оруулалт хийхэд таатай нөхцөл бий болдог. Харин эсрэгээрээ эдийн засгийн хямралын үед зээл авахад хүндрэлтэй, зээлийн хүү өндөр байх нь бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулахад хүндрэл учруулж болзошгүй. Ерөнхийдөө бизнес эрхлэгчид эдийн засгийн үзүүлэлтүүд, зах зээлийн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсийг сайтар судалж, бизнесийн мөчлөгийн өнөөгийн байдлыг харгалзан хөрөнгө оруулалтын үндэслэлтэй шийдвэр гаргах хэрэгтэй.

Бизнесийн мөчлөг болон салбарын хамаарал: Бизнесийн мөчлөгийн үеүд дэх хувьцааны салбар хоорондын хамаарлыг тодорхойлоход ашигладаг түгээмэл арга бол “Секторын эргэлтийн загвар” буюу Sector Rotation Model юм. Энэхүү загвар нь бизнесийн мөчлөгийн үе шаттай холбоотой салбаруудын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийдэг. (Investopedia, 2023) Тэгвэл бизнесийн мөчлөгийн уналтын үед нийтийн аж ахуй, хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хамгаалалтын салбарууд хувьцаа эдийн засгийн хэлбэлзэлд бага мэдрэмтгий байдаг тул илүү сайн ажилладаг.

Бизнесийн мөчлөгийн үе шат бүрд хөрөнгийн ангилал: Уналтын үе шатанд эдийн засгийн өсөлт удааширч, компаниудын орлого буурч, үүний үр дүнд хөрөнгө оруулагчид тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын аюулгүй байдлыг эрэлхийлдэг тул бонд илүү өндөр гүйцэтгэлтэй байдаг. Мөн дараах төрлийн хөрөнгүүдэд хөрөнгө оруулахыг зөвлөдөг. Үүнд:

- Хамгаалалтын хувьцаа
- Алт
- Бэлэн мөнгө
- Бонд

ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Бизнесийн мөчлөгийн үед оновчтой хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэх

Энэхүү судалгааны ажлын хүрээнд бизнесийн мөчлөгийн уналтын үеүдийг тодорхойлж, хувьцааны оновчтой багцыг бүрдүүлэхээр зорьлоо. Бизнесийн мөчлөгийн уналтын үеийг тодорхойлохын тулд тус мөчлөгт нөлөөлөгч индикаторуудаас сонгон ашиглана. Харин хувьцааны оновчтой багцыг бүрдүүлэхийн тулд орчин үеийн багцын онол болох Марковицын онолыг ашиглаж хамгийн бага эрсдэлтэй багц, хамгийн өндөр хүлээгдэж буй өгөөжтэй багц, оновчтой багцыг бүрдүүлэх бөгөөд ингэхдээ хувьцааг тодорхой хэдэн салбарт хувааж эл судалгааны ажилдаа ашиглав.

Хувьцааг сонгохдоо дараах 7 салбарын ТОП–20 индексэд багтах хувьцаанаас бүрдүүлэв. Ингэхдээ салбарыг ангилахын тулд үйл ажиллагааны чиглэлийн код (ISIC 4.0)–ын үндсэн болон дэд ангиллуудыг ашигласан болно.

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Чулуун, хүрэн нүүрс олборлолт
- Нэхмэлийн үйлдвэрлэл
- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Жижиглэн худалдаа
- Санхүүгийн бусад үйл ажиллагаа
- Металлын хүдэр олборлолт

Эрсдэлгүй хүүгийн түвшин: Бодлогын хүүг таамаглахдаа хамгийн энгийн арга болох инфляц болон ДНБ-ий өсөлтийн хамаарлыг ашиглав. Ирэх 2 жилд бодлогын хүү одоогийн байгаа 13 хувиасаа 1–2 хувь буурна гэсэн таамаглалтай байна. Учир нь Азийн хөгжлийн банкнаас эрхлэн гаргадаг тайланд ирэх жилүүдэд инфляцын түвшин буурч, ДНБ-ий өсөлт дундаж буюу тогтмол байхаар өөдрөг таамаглал дэвшүүлжээ. Тиймээс дараа дараагийн тооцоололд эрсдэлгүй хүүгийн түвшин 12 хувь хэмээн авч үзэх болно.

Бизнесийн мөчлөгийн уналтын үе шатуудыг тодорхойлох


Монголбанкнаас 2017 онд бизнесийн мөчлөгийг BBQ алгоритмаар тодорхойлсон бөгөөд үүний үр дүнд Монгол улсад эдийн засгийн уналтын үе дунджаар 4 орчим улирал үргэлжилж байхад өргөжилтийн үе 9 орчим улирал үргэлжилдэг ба дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний хэлбэлзлээс ихээхэн хамааралтай байдаг гэсэн үр дүн гарчээ. Тиймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд юуны өмнө бизнесийн мөчлөгийг ДНБ, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, гадаадын шууд хөрөнгө оруулалт, ТОП–20 индекс, нүүрсний экспорт зэрэг 5 индикаторыг сонгож 2012–2022 оны өгөгдлийг ашиглан энгийн аргаар тодорхойлов.

Эдгээр 5 индикатораас ДНБ-ий өсөлтийг дэлгэрүүлж авч үзье. ДНБ-ий өсөлт Монголбанкнаас тодорхойлсон

бизнесийн мөчлөгүүдтэй давхцаж, ижил учир шалтгааныг тайлбарлаж чадаж байна. Үүнээс харахад 2012 оноос 2015 он хүртэл уул уурхайн экспорт болон ГШХО–ын бууралт, Засгийн газрын өр, улс төрийн тогтворгүй байдал гэхчлэн олон үйл явдлуудаас шалтгаалж Монгол Улсын эдийн засаг уналттай буюу бизнесийн мөчлөгийн уналтын үед байсан. Харин 2016 онд ёроол үедээ хүрснээр дараа оноос нь эдийн засаг сэргэж эхэлсэн буюу өсөлтийн үе шат руу оржээ. 2018 он хүртэл сэргэж байсан ч 2019 онд дэлхий даяар тархсан цар тахал, үүнээс улбаалсан түүхий эдийн үнэ, ГШХО–ын бууралт зэрэг зүйлсээс хамаарч 2020 онд ёроол үедээ хүрснээр 2017–2020 оны хооронд бүтэн нэг бизнесийн мөчлөг болж өнгөрсөн байна. 2021 оноос эдийн засаг буцаж сэргэж эхэлсэн бөгөөд Азийн хөгжлийн банк жил бүр эрхлэн гаргадаг “Азийн хөгжлийн төлөв” эдийн засгийн тайланд Монгол Улсын эдийн засаг экспорт, уул уурхайн салбарын сэргэлт, түүний тээвэр болон бусад салбаруудад үзүүлж буй эерэг нөлөөгөөр 2022 оны 4.8 хувийн өсөлттэй байсан ба 2023 онд 5.4 хувь, 2024 онд 6.1 хувиар тус тус өсөх төлөвтэй байгаа гэж таамаглажээ.

Монгол Улсын бизнесийн мөчлөгийг тодорхойлохдоо дээрх 5 индикаторын 2012–2022 оны хооронд буюу сүүлийн 10 жилийн өгөгдлийг ашиглав. Үүний үр дүнд уналтын үеүдийг 2013, 2015, 2020 он гэж тодорхойлов.

Зураг. Монгол Улсын бизнесийн мөчлөг



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Салбар бүрийн гүйцэтгэлийг тооцоолох

2012–2022 оны компаниудын хувьцааны үнийн мэдээллийг ашиглаж салбар бүрийн тухайн оны өгөөжийг тооцоолж, стандарт хазайлт тооцлоо. Үүний дараагаар салбар хоорондын корреляцийг тооцож үзэхэд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл чулуун, хүрэн нүүрс олборлолтын салбартай дундаж сөрөг хамааралтай, металлын хүдэр олборлолтой сул хамааралтай, бусад салбартай хүчтэй эерэг хамааралтай байна.

Бизнесийн мөчлөгийн уналтын үе тодорхой хэдэн салбар буюу нэхмэлийн үйлдвэрлэл болон арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жижиглэн худалдаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарууд тус тус сайн гүйцэтгэлтэй ажилласан байна. Харин чулуун, хүрэн нүүрс олборлолтын салбар хамгийн муу ажилласан буюу өгөөж нь -17.76 хувь байгаа юм. Тэгвэл өгөөжтэй буюу сайн гүйцэтгэлтэй байсан салбарын хувьцаануудын стандарт хазайлт 27–оос 61 хувийн хооронд буюу өндөр хувьтай байна.

Хүснэгт. Бизнесийн мөчлөгийн уналтын үеийн салбарын гүйцэтгэл

Огноо	Хүнсний үйлдвэрлэл	Нүүрс олборлолт	Металлын хүдэр олборлолт	Нэхмэлийн үйлдвэрлэл	Арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Санхүүгийн бусад үйл ажиллагаа	Жижиглэн худалдаа
2013	20.58%	-30.68%		22.92%	111.01%	15.00%	44.47%
2015	-10.97%	-31.82%		13.83%	4.23%		-9.27%
2020	2.79%	9.23%	82.55%	-28.70%	6.44%	8.12%	22.76%
Өгөөж	4.13%	-17.76%	82.55%	2.68%	40.56%	11.56%	19.32%
СХ	15.82%	23.38%		27.56%	61.02%		27.03%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Уналтын үеийн оновчтой багц бүрдүүлэлт

Марковицын багцын онолын хүрээнд өгөгдсөн өгөөжийн түвшинд хамгийн бага стандарт хазайлт бүхий 30 багцыг тооцсоноос эрсдэлгүй хүү болох 12 хувьтай тэнцүү болон түүнээс их өгөөжтэй байх 19 багц байна.

Уналтын үеийн оновчтой багцын хувьд арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэлийн

салбарын хувьцаа нь зах зээлээс (TOP-20 индекс) бага хэлбэлзэлтэй гэсэн үр дүн гарчээ. Харин жижиглэн худалдаа нь тогтворгүй буюу өндөр хэлбэлзэлтэй гарсан байна. Мөн багцын нийт бета коэффициент 0.76 байгаа нь тус багц харьцангуй зах зээлээс бага хэлбэлзэлтэй буюу уналтын үед хөрөнгө оруулахад оновчтой гэсэн үр дүн гарлаа.

Зураг. Монгол Улсын бизнесийн мөчлөг



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

- Дээрх зургаас харахад стандарт хазайлт бага салбар болох жижиглэн худалдаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрсдэлийн түвшин буурах бүрд багцад эзлэх хувь нэмэгдэж байна. Тиймээс эрсдэлд дургүй, зайлсхийдэг хөрөнгө оруулагчид энэхүү багцын оновчлолыг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтдаа ашиглах боломжтой.
- Харин шарпийн харьцаа хамгийн их багцад салбарын өгөөж хамгийн их салбар болох арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл ихээхэн хувийг эзэлж байна. Шарпийн харьцаа өндөр байгаа нь хөрөнгө оруулалт нь авсан эрсдэлийнхээ хэмжээгээр өндөр өгөөж өгснийг харуулдаг.
- Бизнесийн мөчлөгийн уналтын үеийн хувьцааны салбарын оновчтой багцыг өгөгдсөн өгөөжийн түвшинд хамгийн бага эрсдэлтэй, салбарын тараан байршуулалт сайн хийгдсэн багц гэж тодорхойлсны дагуу дээрх багцыг бүрдүүлэв. Ингэхдээ нэг салбарын эзлэх хувийг жинг 40 хувиас бага байх гэсэн хязгаарлалт тавьснаар салбарын тараан байршуулалтыг оновчлов. Ингэснээр арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 25 хувь, жижиглэн худалдаа 40 хувь, хүнсний үйлдвэрлэл 22 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 13 хувь байх багц бүрдүүлээ.

- Эдийн засгийн уналтын үед хувьцаанд хөрөнгө оруулах гэж буй бөгөөд эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй бол жижиглэн худалдаа болон хүнсний үйлдвэрлэлд ихээхэн хувийн жинг оноож өгөх хэрэгтэй. Харин өндөр өгөөж хүртэхээр зорьж буй бол багцдаа арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын хувьцааг нэмж өгөх нь зүйтэй.

Хувьцаа тус бүрээр бүрдүүлсэн оновчтой багц бүрдүүлэлт

Уналтын үед арьсан бүтээгдэхүүн, жижиглэн худалдаа, хүнсний болон нэхмэлийн үйлдвэрлэлийн салбарын хувьцаанууд сайн гүйцэтгэлтэй байдаг буюу эдгээр салбаруудад дараах хувьцаанууд багтаж буй. Тэгвэл дээрх салбарын оновчлолоор аль компанийн хувьцаанд тус бүр хөрөнгө оруулах хэрэгтэйг тусгаж өглөө.

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл (АПУ ХК, Талх Чихэр ХК, Мах Импекс ХК, Сүү ХК)
- Нэхмэлийн үйлдвэрлэл (Говь ХК)
- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл (Дархан нэхий ХК)
- Жижиглэн худалдаа (Улсын Их Дэлгүүр ХК)

Багцад эзлэх нэг хувьцааг 30 хувиас хэтрэхгүй байх, хувьцааны тараан байршуулалт сайн хийх гэсэн хязгаарлалт тавьснаар 5 хувьцаа бүхий дараах багцыг бүрдүүлснээс Дархан Нэхий, Улсын Их Дэлгүүр, Талх Чихэр ХК-уудын хувьцаа дийлэнх хувийг эзэлжээ.

ДҮГНЭЛТ

Бизнесийн мөчлөг нь эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын хэтийн төлөвийн талаар үнэ цэнтэй мэдээллийг илэрхийлдэг тул хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад улс орнууд ашигладаг. Мөн Засгийн газрууд эдийн засгийн уналтын үед дэмжих шаардлагатай салбаруудыг тодорхойлох, тэлэлтийн үед хөрөнгө оруулалт хийх салбаруудыг сонгох зэрэг хөрөнгө оруулалтын шийдвэртээ бизнесийн мөчлөгийг ашиглаж буй. Бизнесийн мөчлөг оргил цэгтээ хүрснээр уналтын үе болж эргэлтийн цэг бий болдог учраас энэ үе шатанд эдийн засгийн үйл ажиллагаа удааширч, ажил эрхлэлт, үйлдвэрлэл, хэрэглээний зардал буурч эхэлдэг. Энэхүү уналтын үед хөрөнгө оруулагчид Засгийн газрын үнэт цаас, тогтмол эсвэл өсөж буй эерэг мөнгөн урсгалтай компаниудын хувьцаанд хөрөнгө оруулах хандлагатай байдаг.

Монголбанкнаас 2017 онд бизнесийн мөчлөгийг BBQ алгоритмаар тодорхойлсон бөгөөд үүний үр дүнд Монгол улсад эдийн засгийн уналтын үе дунджаар 4 орчим улирал үргэлжилдэг ба дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний хэлбэлзлээс ихээхэн хамааралтай байдаг гэсэн үр дүн гарчээ.

Харин Монгол Улсын хувьд уналтын үеүдийг тодорхойлохдоо Монголбанкнаас тодорхойлсон эдийн засгийн мөчлөгт нөлөөлөгч хүчин зүйлс болох ДНБ, ГШХО-ын орох урсгал, нүүрсний экспорт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ТОП-20 индекс гэсэн үзүүлэлтүүдийг ашиглав. Үүний үр дүнд уналтын үеүдийг 2013, 2015, 2020 онууд гэж тодорхойллоо. Судалгааны үр дүнд бизнесийн мөчлөгийн уналтын үед хувьцааны оновчтой багцыг өгөгдсөн өгөөжийн түвшинд хамгийн бага эрсдэлтэй, салбарын тараан байршуулалт сайн хийгдсэн багц гэж дүгнэв. Ийнхүү бизнесийн мөчлөгийн уналтын үеийн оновчтой багцад арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 25 хувь, жижиглэн худалдаа 40 хувь, хүнсний үйлдвэрлэл 22 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 13 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тараан байршуулалт сайн хийгдсэн байна. Мөн багцын нийт бета коэффициент 0.76 байгаа нь тус багц харьцангуй зах зээлээс бага хэлбэлзэлтэй буюу уналтын үед хөрөнгө оруулахад оновчтой гэсэн үр дүн гарлаа.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Монгол Улсын хувьд ХБҮЦ, ХОС зэрэг нь сүүлийн жилүүдэд гарч ирсэн шинэ хөрөнгө оруулалтын хэрэгсэл тул хөрөнгө оруулалтын багцын тооцоололд ашиглахад дата хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна. Мөн хувьцааны салбарыг оновчлоход санхүү, мэдээллийн технологи (Эрдэнэс сольюшинс ХК) гэхчлэн чухал салбаруудын хувьцааны түүхэн мэдээлэл хүрэлцэхгүй байлаа.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд зөвхөн хувьцаагаар хөрөнгө оруулалтын оновчтой багцыг бүрдүүлсэн тул цааш цаашдаа эрсдэлийг бууруулахын тулд өөр хөрөнгийн ангиллуудыг хослуулах шаардлагатай байна. Тухайлбал, бонд, валютын ханш, түүхий эдийг багц бүрдүүлэхэд ашиглаж болох юм.

Манай улсын бизнесийн мөчлөгийг үе шатууд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, ялангуяа нүүрс, зэсийн үнээс өндөр хамааралтай байгаа тул судалгааны ажлыг гүнзгийрүүлэн түүхий эдийн үнэ болон хувьцааны үнийн хамаарлыг судалбал хэрэгцээтэй үр дүн гарах боломжтой.

ЭХ СУРВАЛЖ

1. Lisa, Mattingly Emsbo; Dirk, Hofschire; Jacob, Weinstein; Cait, Dourney;. (2021). The Business Cycle Approach to Asset Allocation;
2. Audrius Dzikevicius, Jaroslav Vetrov. (2013). Investment portfolio management using the business cycle approach;
3. Van Vliet, Blitz. (2011). Dynamic strategic asset allocation: Risk and return across the business cycle;
4. Sa-Aadu, Shilling and Tiwari. (2006). Portfolio performance and strategic asset allocation across different economic conditions;
5. Akhtar. (2013). Capital structure and business cycles, Accounting & Finance;
6. Xiufang. (2010). The Relationship between stock market volatility and macroeconomic volatility: evidence;
7. Pilinkus. (2010). Macroeconomic indicators and their impact on stock market;
8. Ibrahim. (1999). Macroeconomic indicators and stock prices in Malaysia: An empirical analysis;
9. Siegel. (1991). Does it pay stock investors to forecast the business cycle? ;
10. Л.Даваажаргал, Б.Хүслэн. (2018). Бизнесийн мөчлөгийг тодорхойлох нь;
11. С.Мягмарсүрэн. (2017). Монгол улсын санхүүгийн мөчлөгийг тодорхойлох нь;
12. Б.Дүүрэнбуян. (2022). Бизнесийн мөчлөгийн үе дэх хөрөнгө оруулалтын багцыг оновчлох нь;
13. Л.Даваажаргал, О.Цолмон. (2021). Потенциал үйлдвэрлэлийг тооцох нь;
14. Монголын, Б. Х. (2023). 2022 оны үнэт цаасны арилжааны тайлан;
15. Mangram, M. E. (2013). A Simplified Perspective of the Markowitz Portfolio Theory;
16. Stijn Claessens, M. Ayhan Kose and Marco E. Terrones. (2012). How Do Business and Financial Cycles Interact?;
17. Монголбанк. (2021). Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээл;
18. Bodie, K. M. (2018). Investment, eleventh edition;
19. Алекс Капитал ҮЦК. (2023). 2023 оны төлөв;
20. Санхүүгийн Зохицуулах Хороо. (2023). Үнэт цаасны зах зээл 2022 оны нэгдсэн тайлан;
21. Д.Ган-Очир, Б. (2017). Монгол улсын эдийн засгийн мөчлөг, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс;
22. The Conference Board. (2001). Business Cycle Indicators Handbook;
23. Монголбанк. (2023). Инфляцын тайлан 2023 оны 3 дугаар сар.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №35

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Урт хугацааны даатгал нь хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед даатгуулагчийн орлогыг тасалдалгүй үргэлжлүүлэх, улмаар тэдний гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах үүрэгтэй байдаг.



УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОНЦЛОГ

Даатгалын зүйл нь зөвхөн хүний амь нас, эрүүл мэнд, амьдрах баталгаат байдалтай холбоотой зүйл байна



Даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөр төлөх боломжтой

Урт хугацаатай



Ирээдүйд тохиолдох **тодорхой** эрсдэлийг даатгадаг /нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалт г.м./



Хуримтлал үүсгэх боломжтой



Урт хугацааны даатгалын төрөл



Хугацаат амьдралын даатгал — даатгуулагч зөвхөн даатгалтай хугацаанд нас барсан тохиолдолд эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөр төлнө.

Насан туршийн даатгал — нас барсан тохиолдолд даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.



Хуримтлалын даатгал — Гэрээт хугацааны даатгуулагч, эсвэл эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна.

Тэтгэврийн даатгал — Гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид тэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.



Эрүүл мэндийн даатгал — Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна.

Аннуити даатгал — Даатгагч тохиролцсон хугацаанд даатгуулагчид үечилсэн байдлаар тогтмол мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

S&P 500 ИНДЕКС ТҮҮХЭНД АНХ УДААГАА 5,000.00 НЭГЖИЙГ ДАВЛАА.

2024 оны 03 дугаар сарын 08-ны өдөр АНУ-ын хувьцааны зах зээлийг илэрхийлэгч S&P 500 индекс түүхэн дээд түвшинд хүрч 5,026.61 нэгжээр хаагдлаа. Шинжээчдийн таамаглаж буйгаар 2024 он гарсаар технологийн салбарын компаниудын өндөр өсөлтийг үзүүлсэн нь үүнд нөлөөлжээ.

2024 онд технологийн салбарын томоохон компаниуд “Magnificent Seven” гэгддэг Alphabet, Amazon, Apple, Meta, Microsoft, Nvidia, Tesla зэрэг долоон компанийн хувьцааны үнэ өсөх хандлагатай байгаа бөгөөд “Microsoft” компани 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш 11 гаруй хувиар өссөн бол “Meta” компани ногдол ашиг тарааж эхэлнэ гэж мэдэгдсэний дараа хувьцааны ханш 35 хувиар өссөн байна. Хиймэл оюуны салбарт тэргүүлэгч “Nvidia” компанийн хувьцааны ханш он гарснаар 52 хувиар өсөж технологийн томоохон компаниудыг өсөлтөөрөө тэргүүлсэн юм.

Эх сурвалж: www.washingtonpost.com




ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ДОХИО ӨГӨВ.

АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ яаран бууруулахгүй гэсэн дохиог өгөх төлөвтэй байна. Мөн бодлогын хүүг 5.25 хувиас 5.5 хувьд хэвээр хадгалах хүлээлттэй байгаа юм.

Өнгөрсөн оны долоодугаар сард тус банк бодлогын хүүгээ 5.25 хувиас 5.5 хувь болгож, сүүлийн 20 жилийн дээд түвшинд хүргэсэн юм.

АНУ-ын Төв банкны удирдлагуудын хувьд инфляц хоёр хувь руу буурах нь илүү тодорхой болох хүртэл бодлогын хүүг бууруулахаас зайлсхийж байгаа аж. Хэдий тийм боловч ажилгүйдлийн түвшин саяхан сүүлийн хоёр жилийн дээд түвшинд хүрсэн тул үнийн өсөлт болон хөдөлмөрийн зах зээлд анхаарал хандуулах шаардлага тулгараад байна.

Эх сурвалж: www.bloomberg.com



ЯПОНЫ ТӨВ БАНК 17 ЖИЛИЙН ДАРАА БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ӨСГӨЛӨӨ.

Японы төв банк 2007 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ өсгөж, мөнгөний хэт зөөлөн бодлогоо эргэн харж, урт хугацаатай бага хүүтэй зээлээ зогсоосон бөгөөд бодлогын хүүгээ сөрөг түвшинд буюу -0.1 хувь байсан бодлогын хүүгээ 0-0.1 хувь болгож өөрчиллөө.

Мөн хамтын биржээр арилжаалагддаг /ETF/ сангуудын хувьцааг худалдан авахаа зогсоожээ.

Эх сурвалж: www.nytimes.com





“DOW JONES” ИНДЕКСИЙН ӨСӨЛТ ДЭЭД ЦЭГТ ХҮРЛЭЭ.

НЬЮ-ЙОРК, 2024 оны 02 сарын 05-ны өдөр Америкийн аж үйлдвэрийн гол индекс болох “Dow Jones” түүхэн дээд түвшинд хүрч 269.24 нэгж буюу 0.7 хувиар өсөж 39,781.37 нэгжид хаагдсан байна. Харин “S&P 500” индекс 0.3 хувиар өсөж 5,241.53 нэгжид хүрсэн бол “Nasdaq” индекс 0.2 хувиар өсөж 16,401.84 нэгжид хүрсэн байна.

Америкийн аж үйлдвэрийн индекс 2022 оны есдүгээр сараас өсөж эхэлсэн бөгөөд шинжээчдийн таамаглаж байгаагаар өсөлт дээд цэгт хүрсэн нь Америкийн эдийн засгийн тогтвортой байдалд хөрөнгө оруулагчид итгэж эхэлж байгаатай холбоотой юм.

Эх сурвалж: www.Cnbc.com

БНХАУ-ЫН ҮЛ ХӨДЛӨХИЙН САЛБАР УНАЛТ ҮЗҮҮЛСЭН ХЭВЭЭР БАЙНА.

БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хорооноос “China Evergrande Group” компани хоёр жилийн хугацаанд орлогоо 78 тэрбум орчим ам.доллаароор өсгөж худал мэдээлэл түгээсэн талаар олон нийтэд ил болгов. Ингэснээр тус компанийн үйл ажиллагааг зогсоох шүүхийн шийдвэр гарсан бөгөөд үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч жижиг компаниуд ХонгКонгийн зээлдүүлэгчдээс зээлсэн өрөө төлж чадахгүй болсноор мөн шүүхэд дуудагджээ. 2021 оноос эхэлсэн БНХАУ-ын үл хөдлөхийн салбарын хямрал үргэлжилсээр байгаа бөгөөд тус улсын барилгын компаниуд нийт 111 тэрбум ам.долларын бондын өрөө төлж чадахгүйд хүрээд байна.

Эх сурвалж: Bloomberg.com



БИТКОИНЫ ХАНШ 70,000 АМ.ДОЛЛАРТ ХҮРЧ ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШНИЙГ ДАВЛАА.

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага /SEC/-аас “Spot bitcoin ETF” 11 санд зөвшөөрөл олгосноор зах зээлийн эрэлт нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж эхэлсэн. Хөрөнгө оруулагчид 10 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж крипто зах зээлд томоохон өсөлтийг бий болгосон байна. Долоо хоногийн хугацаанд 2.7 тэрбум ам.доллартой тэнцэх криптовалюта эргэлтэд орж АНУ-ын биржээр арилжаалдаг сангуудын мөнгөн урсгал нэмэгдсэн нь биткоины ханш 70 гаруй хувиар өсөж 70,000 ам долларт хүрсэн байна.

Эх сурвалж: Bloomberg.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

S&P 500 (^GSPC)


5,254.35 +5.86 (+0.11%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 (^N225)


39,758.84 -610.60 (-1.51%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 (^FTSE)


7,952.62 +20.64 (+0.26%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

16,379.46 -20.04 (-0.12%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia